



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**ДҮГНЭЛТ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ УРСГАЛ ЗАРДАЛД
ЗАРЦУУЛАХААР БАТАЛЖ САНХҮҮЖҮҮЛЖ БАЙНА.**

**АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023 ОНЫ
БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТЫН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ**

АУДИТЫН КОД: АР-2024/26-ШТА-ГА

**2024 он
Алтай хот**

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторов “Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/152, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162, “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны А/100 дугаар тушаалын дагуу хийлээ.

Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө"-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Аудитын зорилгыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрэнд гүйцэтгэсэн. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад ОНХС-ийн 2023 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал болон аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, багийн ИНХ, аймгийн Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн холбогдох үйл ажиллагааг хамруулан шалгалаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС 100, АДБОУС-300, АДБОУС-3000-3200-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817:2020 3 Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” MNS 6817:2020 3 Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/69 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт зөвлөмж боловсрууллаа.

Аудитын хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж стандартыг хангуулан, ахлах аудитор М.Атарцэцэг, Б.Цэцэгмаа, аудитор

Э.Сүнжидмаа, Н.Гэрэлмаа, Б.Мөнхбаатар, С.Санчирмаа нар баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын гүйцэтгэх үе шатны талбарын ажлыг 2024 оны 6 дугаар сарын 03-ны өдрөөс 2024 оны 6 дугаар сарын 21-ний өдөр хүртэл гүйцэтгэж, нэгтгэлийг 2024 оны 6 дугаар сарын 24-ний өдрөөс 2024 оны 6 дугаар сарын 28-ны өдөр хийж аудитын тайланг 2024 оны 7 дугаар сарын 05-ны өдөр баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Аудит хийхэд учирсан хүндрэл бэрхшээл

Улсын Их Хурлын сонгууль давхацсан тул зарим сумын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн бодит гүйцэтгэлийг шалгах нөхцөл бүрдээгүй. Мөн сумдын ОНХС хариуцсан мэргэжилтэн шинээр томилогдсон, нягтлан бодогч нар солигдсоноос аудитад шаардлагатай баримт материал гаргаж өгөх ажил удаашралтай, лавлагаа, тодруулга авахад хүндрэлтэй байсан.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Говь-Алтай аймаг нь 141.4 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай, засаг захиргааны нэгжийн хувьд 18 сум, 2 тосгон 88 багтай 16,430 өрхөд 57,328 хүн ам амьдардаг, улсын нийслэл Улаанбаатар хотоос 1037 км алслагдсан. /Эх сурвалж: Статистик мэдээллийн нэгдсэн сан-2023/ Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28-т “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050” хөтөлбөрийн “Бүс орон нутгийн хөгжил” бүлэгт үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлэхээр зорилт дэвшүүлсэн байна.

ОНХС нь Засгийн газраас орон нутгийг хөгжүүлэх зорилгоор өгч буй орлогын шилжүүлэг бөгөөд иргэдтэй хамтран орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилготой. Иргэдийн оролцоотойгоор тус сангийн төлөвлөлт, төслийн үнэлгээ эрэмбэлтэл, хэрэгжилт болон худалдан авах ажиллагаа, хяналт-шинжилгээ үнэлгээ, хөрөнгийн удирдлага гэсэн үндсэн 5 үе шатыг хамран зохион байгуулдаг.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлд ОНХС-аас Говь-Алтай аймагт нийт 15,122.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

Олон Улсын Хөгжлийн Ассоциаци болон Монгол Улсын Засгийн газар хооронд 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр “Тогтвортой амьжиргаа 3” төслийг хэрэгжүүлэхээр Зээл №5487-MN тоот санхүүжилтийн хэлэлцээр хийсэн бөгөөд тус төсөл нь хөдөө орон нутагт тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо, засаглалыг сайжруулах зорилготой үйл ажиллагаа явуулж байна.

Энэ хүрээнд Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр хавсралтаар Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр буюу дээрх төслөөс 2023 онд Говь-Алтай аймагт 187.4 сая төгрөгийн төгрөгийн урамшуулал олгохоор баталжээ.

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн нийт эх үүсвэр, хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг 19,460.0 сая төгрөгөөр ИТХ-аас баталсан боловч санхүүгийн тайлангийн орлогын эх үүсвэр 19,669.8 сая төгрөг буюу баталсан дүнгээс 209.8 сая төгрөгөөр зөрүүтэй.

ОНХС-ийн 2023 оны эх үүсвэрээр 19,460.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 614 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар баталснаас 16,398.3 сая төгрөгийн 493 ажлыг санхүүжүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 64.0 хувь буюу аймаг, Есөнбулаг, Алтай, Дэлгэр, Жаргалан, Цээл, Цогт, Чандмань, Эрдэнэ сумдын 258 төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэлийг газар дээр нь үзэж шалгалаа.

I БҮЛЭГ. ИРГЭД ОЛОН НИЙТЭЭС САНАЛ АВААГҮЙ, ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, АЖЛЫН ДААЛГАВАР, ЗУРАГ ТӨСӨВГҮЙ, ЧИГ ҮҮРЭГТ НИЙЦЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БАТАЛСАН.

Иргэд олон нийтээс санал аваагүй 148 төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан нийт төсөл, арга хэмжээний 24.1 хувийг эзэлж байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 80.0 хувь нь хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдсан байна.

Техник эдийн засгийн үндэслэл, ажлын даалгавар, зураг төсөвгүй 4,622.5 сая төгрөгийн 296 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

II БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН 30.0 ХУВИЙГ УРСГАЛ ЗАРДАЛД ЗАРЦУУЛСАН, БУСАД ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨГ УРТ ХУГАЦААНД ҮНЭЛЭХЭЭР БАЙНА.

Төсөл, арга хэмжээг ИТХ-аар батлахдаа худалдан авах ажиллагааны босго үнэд багтаан нэг төсөл, арга хэмжээг хэд хэдэн багцад хуваан баталснаар шууд худалдан авалт хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасан, аймаг, сумын чиг үүрэгт нийцээгүй 3,126.5 сая төгрөгийн 24 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан байна. Санхүүжилтийг бодит гүйцэтгэлийг үндэслэн олгоогүй нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, хугацаа сунах шалтгаан болсон байна.

Төрийн захиргааны байгууллагаас гэрээнд заасан хугацаа дууссан 42 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж ажиллаагүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр тус сангийн үндсэн чиг үүрэгт хамааралгүй, буцалтгүй тусламж дэмжлэг, урамшуулалд 2,883.3 сая төгрөг зарцуулсан.

III БҮЛЭГ. УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ, ШИЛЭН ДАНСНЫ ЦАХИМ СИСТЕМД БҮРЭН МЭДЭЭЛЭХГҮЙ БАЙГАА НЬ ИРГЭД ОЛОН НИЙТ ИЛ ТОД, ИЖ БҮРЭН, ҮНЭН ЗӨВ, МЭДЭЭЛЛИЙГ АВЧ ЧАДАХГҮЙ БАЙНА.

Захиалагчийн болон, ИТХ-ын дэргэдэх хяналтын хорооноос хэрэгжүүлсэн хяналт хангалтгүй.

Тайлант онд бүрэн хэрэгжиж хүлээн авсан 3,458.4 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй.

Удирдлагын мэдээллийн системд 41 төсөл, арга хэмжээний мэдээллийг дутуу, 386 төсөл, арга хэмжээний мэдээллийг байршуулаагүй.

ДҮГНЭЛТ

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ УРСГАЛ ЗАРДАЛД ЗАРЦУУЛАХААР БАТАЛЖ САНХҮҮЖҮҮЛЖ БАЙНА.

Аудитаар аймгийн ИТХ-ын даргад 948.5 сая төгрөгийн 3 албан шаардлага, 2 заалт зөвлөмж, аймгийн Засаг даргад 0.8 сая төгрөгийн төлбөрийн акт, 2,658.4 сая төгрөгийн 10 заалт албан шаардлага, 1 заалт зөвлөмж, сумдын ИТХ-д 3,666.9 сая төгрөгийн 37 заалт албан шаардлага, 407.7 сая төгрөгийн 26 заалт зөвлөмж, сумдын Засаг дарга нарт 89.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 4,825.6 сая төгрөгийн 37 заалт албан шаардлага, 38 заалт зөвлөмж, аймгийн Татварын газарт 485.6 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлээ.

ЗӨВЛӨМЖ:

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ДАРГАД:

-  Хөгжлийн бодлогын урт дунд богино хугацааны баримт бичигтэй уялдаатай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж байх
-  Төсөл, арга хэмжээний явц үр дүнд тогтмол хяналт тавьж, хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлж ажиллах

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД:

-  Аймгийн ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн ажлын тухайд аймгаас хяналт хэрэгжүүлж байх

СУМДЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА НАРТ

-  Хөгжлийн бодлогын урт дунд богино хугацааны баримт бичигтэй уялдаатай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж байх
-  Төсөл, арга хэмжээний явц үр дүнд тогтмол хяналт тавьж, хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлж ажиллах
-  Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг эх үүсвэртэй нь уялдуулан батлах

СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

-  Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээг тайлант жилд нь багтааж хэрэгжүүлэх
-  Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээнд санхүүжилтийг үе шаттай олгохоор тусгах
-  Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах

АЙМГИЙН ТАТВАРЫН ГАЗАРТ

-  Татварын нэвтрэлтийн нэгдсэн системд төлбөрийн баримт шивээгүй аж ахуйн нэгжүүдэд хяналт хийх